



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХОРЬДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 05

Чингис хот

Үнэ бууруулж худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээ”-ний 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хорьдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 49,600,000 төгрөгийн балансын үнэтэй, 49,600,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, үлдэх өртөггүй 43-80 ХЭҮ улсын дугаартай ЖАК маркын автомашиныг анхны дуудлага худалдааны үнэ 2,500,000 төгрөгөөс 50 хувиар үнэ бууруулж 1,250,000 төгрөгөөр худалдахаар тогтоосугай.

2. Эд хөрөнгийг үнэ бууруулан худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Аймгийн Засаг дарга Ц.Чогсомжавт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн хороо /Ц.Чинзориг/-нд даалгасугай.

ДАРГА



Г. ХЭРЛЭНЧУЛУУН